



МОНГОЛ УЛС  
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 07 сарын 08 өдөр

Дугаар А/109

Номгон

"Бид Хонгорын залуус-2023" залуучуудын нэгдсэн  
чуулган зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.1, Баянхонгор аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 2.1.7, 2.3.3, Аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.3.7, 2.8.3, Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны 2022 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн "Аймгийн 2023 оны хөгжлийн төлөвлөгөөг батлах тухай" 12/54 дүгээр тогтоолын "Бодлогын баримт бичгүүдийн хэрэгжилтийг хангах 6.1.3 дахь заалтын задаргаа"-ны 7, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын VIII хуралдааны "2023 оны төсөвт өөрчлөлт оруулах тухай" 15/42 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтын 34 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1."Залуучуудын сэтгэл зүй, хөгжил, эрүүл мэнд, боловсрол, хөдөлмөр эрхлэлт, нийгмийн оролцоог дэмжсэн хөтөлбөрт" арга хэмжээний 2022-2025 оны төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах зорилгоор "Бид Хонгорын залуус-2023" залуучуудын нэгдсэн чуулган зохион байгуулсугай.


2."Бид Хонгорын залуус-2023" залуучуудын нэгдсэн чуулган зохион байгуулах хөтөлбөрийг нэгдүгээр, зардлын тооцоог хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3.Арга хэмжээнд зарцуулах 22.494.320 (Хорин хоёр сая дөрвөн зуун ерэн дөрвөн мянга гурван зуун хорин) төгрөгийн зардлаас 15.000.000 (Арван таван сая) төгрөгийг аймгийн 2023 оны хөгжлийн төлөвлөгөө хэрэгжүүлэх зардлаас олгохыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (С.Байгалмаа)- т зөвшөөрсүгэй.

4.Залуучуудын нэгдсэн чуулганыг чанартай зохион байгуулж, удирдлага арга зүйгээр хангаж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтэс (В.Наранчимэг)-т үүрэг болгосугай.


5.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Энхжаргал)-д даалгасугай.

ДАРГА



Д.МӨНХСАЙХАН

Аймгийн Засаг даргын Тамгын Газрын Дугаар сарын  
...-ны өдрийн ... дүгээр захирамжийн  
нэгдүгээр хэсэглэл



## “БИД ХОНГОРЫН ЗАЛУУС-2023” ЗАЛУУЧУУДЫН НЭГДСЭН ЧУУЛГАНЫ ХӨТӨЛБӨР

Баянхонгор аймгийн Залуучуудын холбоо нь залуучуудын хүсэл сонирхлыг үндэслэн, тэднийг хөгжих нэгдэх, суралцах, нийгэмд байр сууриа олох, зорилгодоо хүрэхэд нь чиглүүлэн хөтөлж, зорилготой мөрөөдөлтэй, эх орныхоо хөгжил дэвшлийн төлөө цохилох зүрхтэй хонгор нутгийн залуучуудыг идэвхжүүлэн ажиллаж байгаа залуучуудын малгай байгууллага юм.

Бид Баянхонгор аймгийн залуучуудын хөгжил, оролцооны хүрээнд хийж хэрэгжүүлэх аймгийн “Хонгорын залуус 2050” нэгдсэн бодлогын хөтөлбөрийг боловсруулан ажиллаж байгаа бөгөөд тус ажлын хүрээнд “Бид Хонгорын залуус - 2023” чуулганыг зохион байгуулж байна.

**1.ЗОРИЛГО:** Баянхонгор аймгийн залуучуудын асуудал эрхэлсэн төрийн болон төрийн бус байгууллагуудын алсын хараа, бодлогын уялдааг сайжруулах, залуучуудын хөгжлийг дэмжих, тэдний эрх ашигт эергээр нөлөөлөх аливаа асуудлыг аймаг, сум болон төрөөс баримталж буй бодлого, шийдвэрт тусгах, манлайлал, багаар ажиллах ур чадварыг хөгжүүлэх.

**2.ЕРӨНХИЙ ЗОХИОН БАЙГУУЛАГЧ:** Баянхонгор аймгийн Залуучуудын холбоо

**3.ХАМТРАН ЗОХИОН БАЙГУУЛАГЧ:** Баянхонгор аймгийн Засаг даргын тамгын газар, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар

**4.ХАМРАХ ХҮРЭЭ:** Баянхонгор аймгийн 21-35 насны салбар бүрийн залуучуудын төлөөлөл

### 5.ЧУУЛГАНД ОРОЛЦОГЧИД:

| № | Нэр            | Хамрах хүрээ  | Оролцох хүний | Нийт тоо |
|---|----------------|---|---------------|----------|
| 1 | 19 Сум         | Сумын засаг даргын тамгын газрын дарга                                      | 1             | 152      |
|   |                | Сумын залуучуудын зөвлөлийн төлөөлөл  | 1             |          |
|   |                | МЗХ-ны сумдын салбар холбоо   | 2             |          |
|   |                | Сумын АЗХ тэргүүн   | 1             |          |
|   |                | Сумын 8ЮУ тэргүүн   | 1             |          |
|   |                | Малчин залуучуудын төлөөлөл (эр, эм)  | 2             |          |
| 2 | Баянхонгор сум | Хөгжлийн бэрхшээлтэй иргэд  | 2             | 30       |
|   |                | Залуучуудын холбоо  | 11            |          |
|   |                | 8ОУ тэргүүн   | 1             |          |
|   |                | АЗХ тэргүүн   | 1             |          |
|   |                | Сумын залуучуудын зөвлөлийн төлөөлөл  | 3             |          |
|   |                | Бусад(ажил идэвхтэй хайж буй залуучуудын төлөөлөл, хувиараа бизнес эрхлэгч, | 12            |          |

|      |  |                      |     |
|------|--|----------------------|-----|
| 3    | МЗХ-ны Баянхонгор аймаг дахь салбар холбоо                             |                      | 25  |
| 4    | Хүндэт зочид   |                      | 15  |
| 5    | Хамтлаг дуучид   |                      | 8   |
| 6    | Баянхонгор аймгийн Залуучуудын зөвлөл                                  |                      | 3   |
| 7    | Баянхонгор аймгийн Залуучуудын холбооны дэргэдэх Эмэгтэйчүүдийн зөвлөл |                      | 10  |
| 8    | Хамтран ажиллагч байгууллага   | Эрүүл мэндийн газар  | 2   |
|      |  | Онцгой байдлын газар | 2   |
|      |  | Цагдаагийн газар     | 2   |
| Нийт |  |                      | 249 |

**6.ХУГАЦАА:** 2023.07.05-2023.07.07

**7.ХОЛБОО БАРИХ:** 88912171, 88829969, 91946161

**8.БАЙРШИЛ:** Баянхонгор аймаг Эрдэнэцогт сум "Өвгөн жаргалант" хүүхдийн

зуслан

**9.АНХААРАХ АСУУДАЛ:**

а.Сумууд өөрсдийн тээврийн хэрэгсэлтэй явж, аюулгүй байдлаа хариуцах.


б.07 сарын 01-ний дотор чуулганд оролцогчдын мэдээллийг эцэслэж ирүүлэх

в.Чуулганд оролцоходоо согтууруулах ундаа хэрэглэхгүй байх

**10.ЗОХИОН БАЙГУУЛАГДАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА**

| №   | Үйл ажиллагаа                       | Хугацаа     | Хаана зохион байгуулагдах                    |                        |
|---|-------------------------------------|-------------|--|------------------------|
| <b>2023.07.05-ны өдрийн үйл ажиллагаа</b> |                                     |             |  |                        |
| 1   | Бүртгэл                             | 08:00-09:00 | Баянхонгор аймгийн хүүхдийн "Тэмүүжин" театр |                        |
| 2   | Нээлт                               | 09:00-10:00 |  |                        |
| 3   | "Өвгөн жаргалант" зуслан руу хөдлөх | 10:00-12:30 |  |                        |
| 4   | Бүлгийн зохион байгуулалтад оруулах | 12:30-13:00 |  |                        |
| 5   | Өдрийн хоол                         | 13:00-15:00 |  |                        |
| 7   | Сургалт                             | 14:00-17:30 |  |                        |
| 9   | Оройн хоол                          | 17:30-19:30 |  |                        |
| 10  | Сургалт                             | 19:00-20:30 |  |                        |
| 11  | Танилцах үдэшлэг-Галын наадам       | 20:30-23:30 |  |                        |
| <b>2023.07.06-ны өдрийн үйл ажиллагаа</b> |                                     |             |  |                        |
| 12  | Өглөөний дасгал                     | 07:30-08:00 |  | Өвгөн жаргалант зуслан |
| 14  | Өглөөний хоол                       | 08:00-10:00 |  |                        |
| 15  | Дүгнэлт хэлэлцүүлэг                 | 10:00-12:00 |  |                        |
| 17  | Өдрийн хоол                         | 12:00-14:00 |  |                        |
| 18  | Хөгжөөнт тэмцээн                    | 14:00-17:30 |  |                        |
| 20  | Оройн хоол                          | 17:30-19:30 |  |                        |
| 21  | Чөлөөт арга хэмжээ                  | 20:00-23:30 |  |                        |
| <b>2023.07.07-ны өдрийн үйл ажиллагаа</b> |                                     |             |  |                        |
| 22  | Өглөөний дасгал                     | 08:00-08:30 | Өвгөн жаргалант зуслан                       |                        |
| 24  | Өглөөний цай                        | 08:30-11:00 |  |                        |
| 25  | Баянхонгор аймаг руу хөдлөх         | 11:00       |  |                        |

Аймгийн Засаг даргын \_\_\_\_\_ оны \_\_\_\_\_ дугаар сарын  
 \_\_\_\_\_ -ны өдрийн \_\_\_\_\_ дүгээр захирамжийн  
 хоёрдугаар хэвсгэл



БИД ХОНГОРЫН ЗАЛУУЧУУД-2023” НЭГДСЭН ЧУУЛГАНЫГ  
 ЗОХИОН БАЙГУУЛАХАД ШААРДАГДАХ ТӨСВИЙН ЗАДАРГАА

| №    | Зардал                       | Тоо ширхэг | Хэмжих нэгж | Нэгжийн үнэ | Нийт үнэ          | Санхүүжилтын эх үүсвэр |
|------|------------------------------|------------|-------------|-------------|-------------------|------------------------|
| 1    | 2                            | 3          | 4           | 5           | 6                 | 7                      |
| 1    | Хоол, байр                   | 150        | хүн         | 60,000      | 9,000,000         | АЗДТГ                  |
| 2    | Сургалт                      | 3          | хүн         | 1,500,000   | 1,500,000         | АЗДТГ                  |
| 3    | Шатахуун (машин, Мотор)      | 244        | литр        | 2,530       | 617,320           | АЗДТГ                  |
| 4    | Дэвтэр                       | 300        | ширхэг      | 6,000       | 1,800,000         | Залуучуудын холбоо     |
| 5    | Бал                          | 300        | ширхэг      | 800         | 240,000           | АЗДТГ                  |
| 6    | Бугуйвч                      | 300        | ширхэг      | 1,500       | 450,000           | Залуучуудын холбоо     |
| 7    | Зохион байгуулагчдын пудволк | 30         | ширхэг      | 25,000      | 750,000           | Залуучуудын холбоо     |
| 8    | Техник түрээс                | 1          | ширхэг      | 1,500,000   | 1,500,000         | Залуучуудын холбоо     |
| 11   | Тэмцээний шагнал             | 1          | ширхэг      | 2,000,000   | 2,000,000         | Залуучуудын холбоо     |
| 12   | Хэвлэл, тохижилт             | 1          | ширхэг      | 1,800,000   | 1,800,000         | АЗДТГ                  |
| 13   | Ундаа                        | 465        | ширхэг      | 1,800       | 837,000           | АЗДТГ                  |
| 14   | Ус                           | 1,000      | ширхэг      | 1,000       | 1,000,000         | АЗДТГ                  |
| 15   | Бусад зардал                 | 1          | ширхэг      | 1,000,000   | 1,000,000         | Залуучуудын холбоо     |
| Нийт |                              |            |             |             | <b>22.494.320</b> |                        |

\_\_\_\_\_ ооо \_\_\_\_\_